



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/497

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйл 8.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит XXIII хуралдааны 04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаар орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээний нэр, төсөвт өртгийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардлыг Засаг дарга дансны Агаарын бохирдол бууруулах зардал”-аас гаргаж зарцуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Тус арга хэмжээний “Хоёр тарифт ухаалаг тоолуур болон үнс баригч худалдан авах” ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуульд нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг аймгийн худалдан авах ажиллагааны (Б.Должинсорогдог)-т даалгасугай.

4. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын ажлыг үр дүнтэй зохион байгуулах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуульд нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга (Б.Өнөрбат)-д үүрэг болгосугай.

5. Агаар орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж, тайлагнан ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т тус тус даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

Засаг даргын 2024 оны 09 дүгээр
сарын 25 өдрийн 1447 дугаар
захирамжийн хавсралт

ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Хоёр тарифт ухаалах тоолуур худалдан авах /Мөрөн сумын агаарын чанарын бүсэд байгаа айл өрхүүдэд олгох/.	2024	2024	20.0	20.0
2	Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого явуулах	2024	2024	7.3	7.3
3	Үнс баригч худалдан авах /14-р багт байрлах халаалтын зуух	2024	2024	9.0	9.0
4	Агаарын чанарын бүсэд хамрагдаж байгаа айл өрхүүдийн дунд сургалт, нөлөөллийн зохион байгуулах	2024	2024	5.5	5.5
5	Нийт дүн			41.8	41.8

оОо